



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2018 оны 09 сарын 03 өдөр

Дугаар А/538


Эрдэнэт

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6/а/, 29.2 дахь заалт, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1.10 дахь заалт, Батлан хамгаалахын сайдын аймгийн Засаг даргатай 2018 онд хамтран ажиллах гэрээг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дэлхийн хоёрдугаар дайны төгсгөл, 1945 оны Чөлөөлөх дайнд оролцож ялалт байгуулсаны түүхт 73 жилийн ойг тохиолдуулан тус аймагт оршин суугаа дайнд оролцсон ахмад дайчин Ш.Сүрэнжав, Г.Дугаржав, Ж.Донормаа, Д.Пүрэвжав нарт хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулахыг Цэргийн штаб /хурандаа н.Батсуурьт/-т даалгасугай.

2.Хүндэтгэлийн арга хэмжээнд шаардагдах 420000 /Дөрвөн зуун хорин мянган/ төгрөгийг Төрийн захиргааны ажилтны, цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагчдын, дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний цэргийн бэлтгэл сургалтыг зохион байгуулах, цэргийн тоо бүртгэл явуулах зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА 

Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2018 оны
08 дугаар сарын 23-ны өдрийн
А/СЗХ дугаар захирамжийн хавсралт

**АХМАД ДАЙЧДАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХЭД
ШААРДАГДАХ ТӨСВИЙН ТООЦОО**

№	Ахмад дайчдын овог нэр	Тоо хэмжээ	Нэгж	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Шагдарын Сүрэнжав				100000
2	Гончигийн Дугаржав				100000
3	Жамъянгийн Донормаа				100000
4	Дашдаваагийн Пүрэвжав				100000
5	Хадаг	4	Ширхэг	5000	20000
6	Бүгд				420000

00